



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2017 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 23

Есөнбулаг сум

**Аймгийн Сонгуулийн хороог татан
буулгах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг сонгох сонгуулийн хороодыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах аймгийн сонгуулийн хороо амжилттай ажиллаж, сумдын ИТХ-ын сонгууль зохион байгуулагдаж дууссан тул аймгийн Сонгуулийн хороог татан буулгасугай.

2. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 41, 45 дугаар тогтоолуудыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ